



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 11

Шивээговь сум

Ц.Эрдэнэбатын цалинг шинэчлэн
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25-р зүйлийн 25.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Засгийн газрын 2019 оны 472 дугаар “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол, Засгийн газрын 2004 оны 43 дугаар “Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 43.2, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн нэг дүгээр хуралдаанаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Эрдэнэбатын цалинг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үндсэн цалинг 1052207 /нэг сая тавин хоёр мянга хоёр зуун долоо/ төгрөг, онцгой нөхцөлийн нэмэгдэл 30 хувийг үндсэн цалингаас сар бүр бодож олгохыг ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /А.Дэлгэрзаяа/, нягтлан бодогч /О.Дөлгөөн/ нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭБАТ